

“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГОД ТУСГАГДСАН ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

Нэг. Ерөнхий мэдээлэл

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод туссан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хамаарах зорилт, арга хэмжээний биелэлтийг 2024 оны хэрэгжилтийг гарган, хэрэгжилтийн байдалд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

“Алсын хараа - 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод 2023 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэрэгжүүлэх 51 арга хэмжээ туссан байна.

Хоёр. Үнэлгээний дүн

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэрэгжүүлэх 51 арга хэмжээ туссанаас 2024 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилт **86.07** хувьтай буюу “**Тодорхой үр дүнд хүрсэн**” байна.

Арга хэмжээний хэрэгжилт:

- Зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан **100** хувьтай **14** арга хэмжээ;
- Зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа буюу **90** хувьтай **23** арга хэмжээ;
- Тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу **70** хувьтай **11** арга хэмжээ;
- Тухайн зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн **50** хувьтай – **3** арга хэмжээ;

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт
(Үйл ажиллагааны чиглэлээр)

/2024 оны жилийн эцсийн байдлаар/

№	Чиглэл	Арга хэмжээ	Хэрэгжилт (Хувиар)
1	Хүний хөгжил	28	84.2
2	Амьдралын чанар дундаж давхарга	21	88.09
3	Амар тайван аюулгүй нийгэм	2	100
4	Нийт	51	86,07

/Үнэлгээ газраар/

№	Нэгжийн нэр	Арга хэмжээ	Хэрэгжилт (Хувиар)
1	Хөдөлмөрийн бодлогын газар	25	86
2	Нийгмийн хамгааллын бодлогын газар	11	90
3	Хүн амын хөгжлийн бодлогын газар	8	85
4	Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	7	81,4
5	Төрийн захиргааны удирдлагын газар	0	0
6	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	0	0
7	Салбарын хяналтын газар	0	0
	Нийт	51	86,07

Гурав. Зөвлөмж

1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод туссан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хамаарах зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг болон яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллах
2. Зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд явцын хяналт тавьж хяналт, шинжилгээ, үнэлгээнээс гаргасан зөвлөмжийн хүрээнд хариуцлагыг сайжруулж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах.
3. Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээнүүдийг цаг тухай бүрт нь хяналт тавьж, шалтгаан үр дагаврыг харгалзан асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн арга хэмжээг авч ажлыг эрчимжүүлэх.
4. Зорилтот түвшинг тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдах арга хэмжээний хүрэх үр дүнтэй холбох, төлөвлөгөөний биелэлтийг гаргахдаа эдгээр үзүүлэлтүүдийн хүрсэн түвшинг тодорхойлж байх.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТЫН ГАЗАР